



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 87

Улаанбаатар хот

┌ *Үнэт цаас бүртгэлээс хасах тухай* ┐

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 05-р сарын 21-ний өдрийн 172 тоот тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 58 дугаар зүйл, 59 дүгээр зүйлийн 1 дэх заалт, “Тэгш” хувьцаат компанийн 2014 оны 05-р сарын 26-ны өдрийн 14/14 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу хийсэн бүртгэлийн шалгалтын тайланг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. “Тэгш” хувьцаат компанийн гаргасан нийт 156,857 ширхэг хувьцааг “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн бүртгэлээс хассугай.
2. Холбогдох мэдээллийн санд өөрчлөлт оруулж, “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” хязгаарлагдмал хувьцаат компанид хадгаламжаас хасах мэдэгдэл хүргүүлэхийг Үйл ажиллагааны газар /Б.Тунгалаг/-т үүрэг болгосугай.
3. “Тэгш” хувьцаат компани зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилж хязгаарлагдмал хариуцлагатай компани болж, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн бүртгэлээс хасагдсан тухай мэдээллийг олон нийтэд хүргэхийг Зах зээлийн хөгжлийн газар /Ж.Мягмарсүрэн/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.БОЛОРМАА

2014 оны 06-р сарын 13

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО
ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ТӨВ ХХК-Д**

ҮНЭТ ЦААС ХАДГАЛАМЖААС ХАСАХ МЭДЭГДЭЛ № 147-д

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 05-р сарын 21-ний өдрийн 172 тоот тогтоол, МХБ-ийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 06-р сарын 13 -ны өдрийн № 17 тоот тушаалыг тус тус үндэслэн “Тэгш” ХК-ийн гаргасан нийт 156,857 ширхэг хувьцааг Төвлөрсөн хадгаламжаас хасахыг мэдэгдье.

ҮЗҮҮЛЭЛТ		БҮРТГЭГДСЭН БАЙДАЛ
Үнэт цаасны нэр :		“Тэгш” ХК
Үнэт цаасны үгсэн код:		HAL
Үнэт цаасны төрөл:		Хувьцаа
Үнэт цаасны тоо /ширхэгээр/		156,857
Үүнээс:	тоо /ширхэг/	0
Төрийн эзэмшил	хувь /%/	0%
Олон нийтийн	тоо /ширхэг/	156,857
Эзэмшил	хувь /%/	100%
Үнэт цаасны нэрлэсэн үнэ /төгрөгөөр/		100
Үнэт цаасны нийт үнийн дүн /төгрөгөөр/		156,857

МХБ-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

МХБ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ДАРГА



Д.БОЛОРМАА

АНХБААТАР ХОТ Б.ТУНГАЛАГ

4/12